Golomt Capital®

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Газрын тос

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.07.25

Golomt Capital®

АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал: **2022 оны 7-р сарын 25**

Өнгөрсөн долоо хоногт алтны ханш 1.15 хувиар өслөө. Харин шинэ долоо хоног эхлэхэд ам.долларын ханш бага зэрэг чангарч алтны ханш уналаа.

Энэ долоо хоногт болох хурлаар ХНС бодлогын хүүгээ 75 суурь нэгжээр өсгөх хандлагатай байна. Сүүлийн инфляцийн түвшин өндөр байгаа нь хүлээгдэж байснаас илүү их хэмжээгээр бодлогын хүүг нэмэгдүүлж магадгүй юм.

АНУ-ын сангийн сайд Жанет Йеллен ням гарагт өгсөн ярилцлагандаа эдийн засгийн өсөлт удааширч байгаа ч ажил эрхлэлтийн байдлын үзүүлэлтүүд сайн гарч байгаа нь нөхцөл харьцангүй сайн байгааг илтгэж байна хэмээжээ.

Өнгөрсөн долоо хоногт Европын төв банк 25 суурь нэгжээр бодлогын хүүг нэмэгдүүлэн хэмээн таамаглаж байсан ч 50 суурь нэгжээр өсгөсөн.

Хэдийгээр алтыг инфляцийн эрсдэлээс хамгаалах хэрэгсэл гэж үздэг ч ам.доллар хэт чангарч байгаа нь хөрөнгө оруулагч нарт алтыг сонирхох боломж олгохгүй байна.

Техник шинжилгээ талаас нь авч үзвэл алтын ханш худалдан авахад боломжит цэг дээрээ ирсэн ч тухайн цэгийг дахиан нэг удаа ирж шалгах магадлал өндөр байна.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*

Golomt Capital®

ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал: **2022 оны 7-р сарын 25**

Дэлхийн хамгийн том нефтийн хэрэглэгч АНУ-ын хүүгийн өсөлт нь шатахууны эрэлтийн өсөлтийг хязгаарлаж магадгүй гэсэн болгоомжлолын улмаас өнгөрсөн даваа гарагт газрын тосны үнэ уналттай эхэллээ.

Брент маркийн нефтийн 9-р сарын фьючерс 48 цент буюу 0.5%-иар буурч, баррель нь 102.72 ам.долларт хүрч, дөрөв дэх өдрөө буурчээ.

Есдүгээр сард нийлүүлэх АНУ-ын West Texas Intermediate (WTI) нефтийн үнэ 65 цент буюу 0.7%-иар буурч, нэг баррель нь 94.05 ам.долларт хүрч, дөрөв дэх өдрөө дараалан буурчээ.

Барууны хориг арга хэмжээний улмаас газрын тосны нийлүүлэлт тасалдан үнэ өссөн. Харин сүүлийн өдрүүдэд ХНС-гийн хүүгээ өсгөх шийдвэр нь эдийн засгийг агшааж газрын тосны эрэлтийг бууруулж магадгүй гэсэн хүлээлтээс үүдэн ханш унаж эхэллээ.

Долдугаар сарын 26-27-нд болох хурлаараа Төв банк бодлогын хүүгээ 75 суурь нэгжээр өсгөх магадлалтай гэж АНУ-ын Холбооны нөөцийн сангийн албаны хүмүүс мэдэгдлээ.

Нийлүүлэлтийн хувьд Ливийн Үндэсний нефтийн корпорац (NOC) хоёр долоо хоногийн дотор олборлолтоо өдөрт 1.2 сая баррельд (bpd) хүргэхээр зорьж байна.

Европын холбоо өнгөрсөн долоо хоногт дэлхийн эрчим хүчний аюулгүй байдалд учрах эрсдэлийг хязгаарлах зорилгоор гишүүн орнуудын тохиролцсон хориг арга хэмжээний дагуу Оросын төрийн өмчит компаниудад гуравдагч орнууд руу газрын тос тээвэрлэхийг зөвшөөрнө гэж мэдэгдсэн

Гэсэн хэдий ч ОХУ-ын Төв банкны ерөнхийлөгч Эльвира Набиуллина баасан гаригт Орос улс нефтийн үнийн дээд хязгаар тогтоохоор шийдсэн орнуудад газрын тос нийлүүлэхгүй гэж мэдэгдэв.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*